

“ЗӨӨЛӨН ХҮЧ”

Нямаахүүгийн Батжаргал¹

Хураангуй: Улс төр судлаач Ж.С.Най 1990 онд олон улсын харилцааны шинэ онолын асуудлыг анх дэвшүүлж, 2004 онд нэрд гарсан “Soft Power: The Means to Success in World Politics” (Зөөлөн хүч бол дэлхийн улс төрийн амжилтанд хүрэх хэрэгсэл) нэртэй номоо хэвлүүлснээс хойш одоо энэ сэдвээр судлаачдын дунд өргөн хэлэлцүүлэг өрнөсөөр байна. Олон улсын харилцаанд идэвхтэй оролцдог нөлөө бүхий байр суурьтай зарим улс орнуудын төр засгийн удирдлагууд ч энэхүү “Зөөлөн хүч”-ний онолыг удирдлага болгон хэрэгжүүлэх улс төрийн шийдэлд хүрэх талаар анхаарал тавьсаар байна.

Удиртгал: Юуны өмнө “Зөөлөн хүч” - ний гэх энэхүү нэр томъёогоор нэрлэгдэх болсон олон улсын харилцааны шинэ онолыг дэвшүүлсэн АНУ-ын эрдэмтэн, Жозеф Жорж Сэмүэл Най гэгч чухам хэн болох талаар эрхэм уншигч танд товч мэдээлэх нь зүйн хэрэг билээ. Тэрээр 1937 онд төрсөн, Харвордын их сургуулийн профессор, үндэсний аюулгүй байдлын цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх зөвлөлийн багийн тэргүүн, Б.Клинтоны засаг захиргаанд Батлан хамгаалахын олон улсын аюулгүй байдлыг хариуцсан орлогч сайд, 1993-1994 онд АНУ-ын тагнуулын үндэсний зөвлөлд тэргүүлэгчээр ажиллаж байсан болно.

* * *

Ж.Найгын бүтээл болон түүний үзэл санааг баримтлагчдын үзэл баримтлал олон улсын улс төрийн бодлогын шинэ либериал / неолибериал / хандлага чиглэлийг үндэслэсэн гэхэд маргах хүн гарахгүй буйзаа. Тэгэхээр “зөөлөн хүч”-ний онол бол дэлхий дахины даяаршлын улс төр, эдийн засаг, дипломатын нэг үндсэн онол нь болж байна.

¹ ШУТИС-ийн Гадаад хэлний институтийн зөвлөх профессор, “Оюун судлахуйн төв”-ийн удирдах зөвлөлийн дарга, магистр E-mail : intel_bat@yahoo.com, mon_mind_study@yahoo.com

“Зөөлөн хүч”- ний онолын эргэн тойронд:

Жозеф Най² “Зөөлөн хүч” бүтээлдээ АНУ-ын орчин үеийн улс төрийн бодлого шинэ либерал онол дээр тулгуурладаг хэмээн үнэлэн Жорж Бушын баримталж байсан бодлогыг шүүмжлэн ялангуяа Иракд явуулсан цэргийн хүчний давамгайлалдаа найдсан найдлагыг Америкийн улс төрийн алдаатай бодлогын бантан хэмээн үзээд АНУ-ыг зөвхөн эдийн засаг, цэрэг зэвсгийн үзүүлэлтээрээ төдийгүй мөн олон улсын харилцаанд “зөөлөн хүч”-ээр нөлөөлөх байдлаараа ч үнэмлэхүй тэргүүлдэг хэмээн баталжээ.

“Зөөлөн хүч” нь: 1. Соёл урлаг, боловсрол, 2. Улс төрийн үзэл суртал, 3. Гадаад бодлого гэсэн гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх ба соёл урлаг боловсрол нь тухайн нийгэм, үндэстэний уламжлал болох үнэ цэнээс бүрдэж байхад гадаад бодлого нь субъектив шинжтэй хамаарал бүхий олон талт бодлогын хамаарал байдаг байна. ”Зөөлөн хүч”, “ Хатуу хүч”- ийг бодвол улс орнуудын удирдлагуудад илүү түвэгтэй байдаг нь үр дүнгийг нь баримжаалж урьдчилан дүгнэхэд хүндрэлтэй байдагтай холбоотой.

Гадаад бодлого нь “Зөөлөн хүч”-ийг хүчтэй болгох эсвэл сулруулах нөлөө үзүүлдэг байна. Энэхүү хүчтэй болгох нөлөө нь мэдээлэлд тустайгаас гадна ерөнхийдөө эдгээр нөлөөллүүдийн хэмжээ уг мэдээллийн хэрэгсэлийг хэрэгэлж байгаа тухайн улс орны нийгэм эдийн засгийн төвшингөөс хамааралтай.

“Зөөлөн хүч” нь явуулж байгаа улс орныхоо геополитикийн сонирхолыг хамгаалахын зэрэгцээ бусад улс орны нийгмийн хүрээнд сэтгэл татсан удирдахуйн соёл, урлаг, боловсролын загваруудыг ашиглах замаар өөрийн бодлого, зорилгоос татгалзах аргагүй болтол нь татан хамааруулах сэтгэл зүйн нөлөөллөөр хэрэгжих технологи мөн. Энэ аргыг зөвхөн өөрийн сонирхолдоо дэлхийд анх эрчимтэй хэрэглэсэн шинэ түүхийн эзэн бол АНУ юм.

Энэ технологи бүх дэлхийн сая сая хүмүүний оюун санааг эргүүлж “Хүчний” нөлөөнд автвал “амттай” мөрөөдлөөр мансууран “завхралд” ч хүргэж болох аюултай гэдэг нь Украйнд явуулсан ажиллагааны сүйрлийн жишээнээс харагдаж байна. Энэ жишээ АНУ, Европын холбоо, ОХУ, Украйны аль алиных нь алдаатай үйл

2. Nye J. *Soft Power: The Means to Success in World Politics.* – N.Y.: Public Affairs Group.

ажиллагааны золиос болохыг харуулж байгаа төдийгүй “Зөөлөн хүч” нөлөөлөл “Хатуу хүч”/харгис, түрэмгий хүч/ болон урван хувирах урхагтайг мөн харуулсан гашуун сургамж юм.

“Зөөлөн хүч”-ний чадамжийг нэмэгдүүлэх хөшүүрэг нь хүчний байгууллагуудаас явуулах ажиллагаа биш өдөр тутмын ухаалаг гадаад бодлогын үйл ажиллагаа, хэтийн төлөвд чиглэсэн улс орнуудын хоорондын найрсаг харилцаа, гадаад орнуудын шууд солилцооны систем бүхий шууд харилцааг хөгжүүлсэн мэдээллийн урсгалыг хянах боломж болон энэ чиглэлийн мэдээллийн баялаг сан бүхий нийтийн дипломат зэрэг болно.

Ж.Най “зөөлөн хүч”-ний хандлага нь үнэхээр Вашингтоны бодлогод захирагдах илүү ухаалаг, хямд арга мөн гээд “зөөлөн хүч” бол итгэл үнэмшлийн механизмыг ашиглаж бусад орны хэтийн төлөвийн сонголтыг хязгаарлах, АНУ-ын сонирхолд сайн дураараа бөхийлгөх хэрэглүүр гэж нээлттэй тунхагалсан байдаг.

Америкийн тэргүүлэх үзэл баримтлалын орчин үеийн хөгжлийн талаарх тунхаг А.Богатурев³, Д.Айкенберри⁴, К.Уолтец,⁵ З.Бжезинский⁶, Ф.Фукуяма⁷ нарын бүтээлүүдэд тодорхой бичигдсэн. Ялангуяа дэлхийн орчин үеийн улс төрийн системийн хөгжлийн өнөөгийн үе шатуудыг М.М.Лебедев⁸, О.Н.Барабанов⁹, Д.М.Фельдман¹⁰, Ж.Розенау¹¹ нар авч үзжээ.

Энхийн хөтөлбөрт сонголтыг олон улсын террорист байгууллагуудаас “Зөөлөн засаглал”-ыг үндэстэн дамнасан алан хядах үйл ажиллагаанд эх үүсгүүр болгон авч үзэж байгааг М.М.Лебедев,

3. Богатулова А.Д. http://scjournal.ru/articles/issn_1997-292X_2013_3-2_44.pdf<http://www.twirpx.com/file/1254665/2e> издание, испр. и доп. М.: Аспект-Пресс, 2010 - 592 с

4. Жон Айкенберри. http://www.globalaffairs.ru/number/n_11636

5. Уолтц, К. Н.Человек, государство, и война» (1959)

6. Бжезинский З. Великая шахматная доска (Господство Америки и его геостратегические императивы). www.lib.ru/POLITOLOG/AMERICA/bzhezinskij.txt

7. Фукуяма.ф.: идет ли Америка безвозвратно к упадку и разложению часть1,2. uk.wikipedia.org/.../Френсис_Фу.

8. Лебедева М. М.Мировая политика: Учебник для вузов 1 - 2-е изд.,испр. и доп.- М.: Аспект Пресс, 2007.- 365 с.

9. Барабанов .О. Н. Основные концепции глобального управления <http://www.gua.convdocs.org/docs/241/index-1581144.html>

10. Фельдман Д.М. Политология конфликта (учебное пособие). - М., 1997

11. Розенау.Ж: Управление неуправляемым: проблема глобального...polit-inform.ru/showObject/objID/89

“Зөөлөн хүч”

А.В.Малашенко¹², Д.Б. Малашево¹³ нар анхааруулсан байдаг.

Америкийн судлаач Дж.Найн дэвшүүлсэн “зөөлөн засаглал” гэдэг ойлголт “зөөлөн хүч”, “уян засаглал”, “ухаалаг хүч” зэрэг нэр томъёолуудтай угтаа агаар нэгэн зүйл мөн. Ж.Найн дэвшүүлсэн “зөөлөн засаглал” – ын үзэл баримтлал улс төрийн хүрээнд судлаачдын санаа бодлыг төвлөрүүлсэн ноцтой маргаан дэгдээж энэ нь “зөөлөн засаглал”- ын тухай ойлголтыг улам бүр өргөтгөн баяжуулж байгаагийн нэг нь түүний энэхүү нийтлэл болно.

“Ухаалаг хүч”-ний стратеги нь орчин үеийн даяаршилыг цогцлоох төрөл бүрийн арга хэрэгслүүдтэй уялдсан улс орнуудын гадаад бодлогын урт удаан хугацаанд хэтийн төлөвтэй уялдан хэрэгжих зүйл юм. Энэ нь “Ухаалаг хүч”-ний бодож боловсруулсан шинжлэх ухаан, онолын төвшин дахь үзэл баримтлал “тогтвортой хөгжил”-ийн («sustainable development») үзэл баримтлалын боловсруулалт болж хувирна гэсэн үг юм.

“Зөөлөн хүч”- ний удаан хугацааны хэтийн төлөвт бодлого нь олон улсын харилцаанд хатуу бодлогоосоо илүү үр дүнтэй давуу өгөөжтэй болох нь Орос, Хятадын зүгээс Латин Америкийн орнуудтай харилцаа холбоогоо улам бүр бэхжүүлэх талаар сүүлийн үед олон улсын хэмжээнд авч явуулж байгаа улс төрийн бодлогын амжилт, үр дүнгээр батлагдаж байна. Ийм нөхцөлт үйл ажиллагааг явуулахгүй байгаа алдаанаасаа болоод Латин Америкийн ихэнх орон АНУ-д итгэл алдран зай барихад хүрч тухайн бүс нутагт АНУ-ын байр суурь улам бүр суларсаар байна.

“Зөөлөн хүч”- ний үзэл баримтлал хөгжиж буй ертөнцөд юуны өмнө Энэтхэг, Хятад, Латин Америк ба Карибын сав газрын улс орнуудыг хамааран түгэн дэлгэрч байгаа ч үр дүнд хүрэх хугацаа харахан болоогүй байна.

АНУ болон Европын холбоо, улс хоорондын харилцааны асуудлаар учраа олж ядан байх богино хугацаанд БНХАУ Африкийг тэр аяар нь эзлээд Өмнөд Америкт бат бэх суурь тавиад байна. Энэ

12. Малашенко А. В. Просто террорист / Алексей Малашенко. — М. : Огонёк : Terra-Книжный клуб, 2008. — 30, [1] с.; 16 см. - (Библиотека "Огонёк").

13. Мальшева Д.Б. Центральноазиатский узел мировой политики. – М.: ИМЭМО РАН, 2010. – 100 с.

бүхэн олон улсын харилцаанд шинээр дахин мэндэлсэн дорнын “зөөлөн хүч”- ний үзэл баримтлал, ”ухаалаг хүч”- ний үр өгөөж гэлтэй. Жозеф Найн үзэж байгаагаар: Хятадын “Зөөлөн хүч” соёл урлагийн талаараа илүү ихийг эзэмдэж байна. Хятадын уламжлалт соёл бүхний сонирхолыг байнга л онцгой татдагийн нэг жишээг өнөөгийн Күнзийн сургалт явуулдаг 400 сургууль дэлхийн өнцөг булан бүрт сургалтаа явуулж байгаагаас харж болно. Тэд хятад хэлээ зааж, улс орныхоо соёл, урлагийг өргөн хүрээтэй түгээж байгаа явдал амжилттай явагдаж байна. “Зөөлөн хүч”-ний хувьд Хятад эртний уламжлалтай улс юм, “зөөлөн нь хатуугаа дийлдэг” гэдэг яриа Хятадаас гаралтайг санаагаахтүн. “Зөөлөн хүч”-ний стратеги олон зууны тэртээд Хятадын төрийн бодлогод хэрэглэгдсээр ирсэн технологи юм. Хятадын эртний аугаа сэтгэгч Сунь Цзы¹⁴ бүр м.э ө. VII зуунд “дайснаа тулалдахгүйгээр ялах “ нь юу юунаас илүү болохыг анзаарсан байдаг.

2007онд БНХАУ-ын төрийн тэргүүн Ху Жиньтао ХКН-ын XVII их хурал¹⁵ дээр “зөөлөн хүч”- ний сэдвийг анх дэвшүүлэн тавьж дараа нь өнөөгийн удирдагч Си Зиньпин Хятадын “soft-power”, “зөөлөн хүч”-ийг идэвхтэй ашиглах талаар байнга уриалах болсон. Геополитикийн олон төрлийн чиглэлээр Хятадын олон талт дипломат бодлого тун идэвхитэй ажиллаж байгаа. Сүүлийн 10 жилийн Хятадын хөгжлийн огцом үсрэлт энэ орны олон улсын түвшинд нөлөөлөх нөлөөллийг нь ч улам бүр өсгөсөөр байна

ХКН-ын ТХ-ны IV чуулганы XVI хуралдаан (2004оны 9 сард) Хятадын соёлыг гадагшаа сурталчилах зорилт тавин XVII их хурлын илтгэлд заасан “Зөөлөн хүч” гэдэг нэр томъёог эргэн санахыг тэмдэглэсэн байдаг. XXI зуунд цэрэг зэвсгийн бус аргаар зорилгодоо хүрэх “ухаалаг арга”-аа төгөлдөр болгох гадаад харилцааны улс төрийн номлол Хятадад бий болсон байдал олон улсын хэмжээнд баримталж байгаа улс төрийн бодлогоос нь харагдаж байна. Хятад нийтийн дипломатын хүрээнд хөгжиж байгаа орнуудад соёл, шинжлэх ухааны солилцоо хийх, худалдааны сүлжээнд хамтрах, хөрөнгө оруулалт болон олон улсын хүмүүнлэгийн тусламжинд анхаарах хандлагаа

14. Сунь-Цзы. Трактат о военном искусстве. Пер. с др. кит. Шабан В. А. . — С.-Пб. альманах «Ф2», 2008.
15. КНР 17-м съезде КПК (2007 г.) <https://ru.wikipedia.org/wiki/XVII> О задачах и проблемах компартии Китая в свете требований IV пленума ЦК КПК <http://riss.ru/index.php/analitika/931-o-zadachah-i-problemah-kompartii-kitaya-v-svete-trebovaniy-iv-plenuma-ck-kpk#.VPZXUvmUc8y>

“Зөөлөн хүч”

улам бүр нэмэгдүүлсээр тухайн бүсэд өөрийн байр сууриа бэхжүүлэх зорилгоо богино хугацаанд барьцтай, үр дүндтэй хэрэгжүүлсээр байна. БНХАУ зүүн өмнөд Ази, Номхон далайн орнууд, төв Ази, Африк, Латин Америкийн улс орнуудад соёлын хувьд ч улс төр, эдийн засгийн харилцаанд ч, нийгмийн хүмүүнлэгийн хүрээнд ч эрчимтэй, идэвхитэй, хэтийг харсан, бие даасан “зөөлөн хүч” - ний хүчтэй улс төрийн бодлого явуулж байгаа улс юм.

2006 онд НҮБ-ын 61-р чуулганд оролцож байсан дөрвөн улсын Гадаад хэргийн сайдуудын уулзалтаар анх улс төрийн хамтын ажиллагааныхаа эхлэлийг тавьж байсан Бразил, Орос, Энэтхэг, Хятад, ӨАБНУ хамтарсан “БРИКС”¹⁶ хамтын ажиллагааны форм нь дэлхийн томоохон улс орнуудын нэгдсэн хүчирхэг “зөөлөн хүч”-ний сонирхолыг бодитойгоор харуулсан үйл явдал болоод байна. Шинжээчдийн дүгнэсэнээр “БРИКС” нь эдийн засгийн хүчин чадлын нийлбэрээрээ 2050 он гэхэд дэлхийн хамгийн том бүлэглэл болно гэж тодорхойлж байна. Эдгээр улс орнууд дэлхийн эдийн засгийн чухал чухал нөөцөөр арвин баялаг тухайлбал: Бразил арвин хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй, БНХАУ хүчирхэг үйлдвэрлэлийн баазтай, ӨАБНУ байглийн нөөцөөр баялаг, ОХУ арвин эрдэс баялгийн нөөцтэй, Энэтхэг оюун ухааны хямд нөөцтэйн зэрэгцээ эдгээр орны хүн ам нийлээд дэлхийн нийт хүн амын 43%-ийг эзэлж байна. Зөвхөн энэ үзүүлэлтүүдийг л харахад хир том бүлэг үүсэн бий болж бойжиж буй нь тодорхой Энэ бүлэг ирээдүйд улам бүр хүчирхэгжин жинхэнэ утгаараа “том бүлэг” болох нь илт байна!

Сүүлийн жилүүдэд Өрнөдийн болон Оросын судлаачид “зөөлөн хүч”-ний сэдвийг илүүтэй анхаарах болсоноор олон улсын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх өргөн боломж, чадамж байгааг дөнгөж одооноос л мэдэрч эхэлж байх шиг байна.

“Зөөлөн хүч” - ний арга улс орнуудын улс төрийн гадаад бодлогод тусгалаа олон сүүлийн арваад жилээс олон улсын харилцаанд өргөн хэрэглэгдэж мэдээллийн технологийн хөгжил, орчин үеийн харилцаа холбооны сүлжээтэй уялдан байр сууриа улам бүр тэлэн өрөгжсөөр байна.

16. БРИКС-<http://glagol-info.com/news/132404-strany-briks-sposobny-udovletvorit-potrebnosti-rossijskoj-promyshlennosti>

Р. Кохейны сонгомол тодорхойлолтоор олон улсын харилцааны олон талт хандлага нь гурав буюу түүнээс дээш улс орон өгөгдсөн зорилгод онцгой тохиролцсон тусламжийн хүрээнд зохицуулах практикийг өөртөө агуулдаг байна. Энэ нь тогтвортой хөгжлийг хангах суурь болно.

“Зөөлөн хүч¹⁷”-ний үзэл санааны шинжлэх ухааны онолын үе шат нь ”тогтвортой хөгжлийн” («sustainable development») хандлага байдгаараа нэн чухал зүйл болдог төдийгүй “тогтвортой хөгжлийн” хандлагын үзэл баримтлалын үндэс нь улс орнуудын хамтын ажиллагааны баримт бичгүүдэд тусгалаа олж хэрэгждэгээрээ чухал ажиллагаа болдог байна.”Тогтвортой хөгжлийн” хандлагын үзэл баримтлалын нөлөөн дор нилээд хэмжээний “зөөлөн хүч” боловсрогдогоороо тогтсон хөгжлийн баримжаат үндсэн стратеги, чиг шугам / үзэл баримтлал/ болдог юм.

Оросын зарим судлаачид «зөөлөн хүч» — ийг ОХУ-ын улс төрийн бодлогын сул тал гэж үздэг төдийгүй “зөөлөн хүч” Оросын гадаад бодлогод байхгүй мэт ярьдаг хүмүүс ч бас бий. “Шинэ боломж, давуу талаар өөрчлөгдөн буй ертөнц дахь Орос орон “ сэдвийн дор 2012 онд зохион байгуулагдсан Оросын бүрэн эрхт элчин сайдууд болон олон улсын байгууллагуудын байнгын төлөөлөгчдийн зөвлөлгөөн дээр ОХУ Ерөнхийлөгч В.В.Путин¹⁸ «...Олон улсын ажиллагаанд манай дипломатуудын хэрэглэсээр ирсэн уламжлалт аргууд хангалттай сайн ч хэрвээ боловсронгуй биш гэж үзвэл жишээ нь “зөөлөн хүч” хэмээн нэрлээд байгаа энэ шинэ технологийн талаар бас бодож үзэх л зүйл» гэж тэмдэглэсэн нь Оросууд “зөөлөн хүч¹⁹”- ний аргад анхаарлаа хандуулаад эхэлчихсэний нотолгоо болно.

“Зөөлөн хүч”-ний нэр томъёололыг анх гаргасан АНУ-ын улс төр судлаач Жозеф Най Германы «Die Welt» сэтгүүлд – Кремлийн “зөөлөн хүч ” хайлж эхэлж байх шиг байна, энэ бол тун ноцтой бүр сүйрлийн үр дагаварт ч хүргэж болох зүйл» гээд тэрээр цааш нь «ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин өөрийнхөө улс орны сонирхолын үүднээс албадлагын аргыг хэрэглэхийг оролдлоо, энэ нь Оросын эдийн

17. Clinton: Use "Smart Power" In Diplomacy, CBS News (13 января 2009).

18. Россия вменяюемся мире: преамбульность приоритетов и новые возможности». 09.07.2012 / Совещание послов и постоянных представителей... ruszim.org.zw/index.php?catid=82..

19. Смирнов А.И., Кохтолина И.Н. Глобальная безопасность и «мягкая сила 2.0»: вызовы и возможности для России / А.И.Смирнов, И.Н.Кохтолина. – М.: ВНИИгеосистем, 2012. – 252 с.

“Зөөлөн хүч”

засгийг хатуу хоригт орууллаа...Оросын өнөөгийн эдийн засаг нефть, байгалийн хий зэрэг өндөр үнэтэй нөөцөөрөө ч сэргэн босох чадваргүй болсон. Байгалийн хийгээ бага үнээр гучин жилийн хугацаатай Хятадад нийлүүлэхээр БНХАУ-тай саяхан зурсан хэлэлцээр ч тус болж чадахгүй» хэмээн үзэж байна. Энэ мэдэгдлийг уншаад ОХУ-аас орчин үед явуулж буй гадаад бодлоготой нь харьцуулахад Ж.Най хэтэрхий туйлширсан мэт санагдана.

“Зөөлөн хүч”- ний стратегийг хэрэгжүүлэх улс хоорондын хамгийн боломжтой субъект бол нэгэн зорилгод чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэг мөн. Бүх нийтийг хамарсан нөлөөлөл, улс төрийн систем дэхь улс хоорондын харилцааны хувьсал зэрэг нь зөвхөн нэг улсын хэмжээнд хязгаардмал явагддаг ч зүйл бас биш ээ. Энэ нь сонирголоороо нэгдсэн олон улсын бүлэглэлийн хүрээнд биелэлээ олох хамгийн тохиромжтой стратеги юм. Олон улсын харилцаан дахь ийм боломж энэ цагт Евразийн өргөн уудам бүсд төдийгүй Латин америк, Африкийн улс орнуудын хүрээнд бүрдэн үүнд БНХАУ, ОХУ гадаад бодлогынхоо хүрээнд эрчимтэй гэж хэлж болохоор тэргүүлэх байр сууринаас идэвхийлэн оролцож байна.

ОХУ-ын ерөнхийлөгч В. Путин 2011 онд «Известия²⁰» сонинд тавьсан нийтлэлдээ Европ, Ази, номхон далайн бүсийн үндэстэн хоорондын хүчтэй нэгдлийг санал болгон дэвшүүлсэн байдаг. Энэ үзэл баримтлал XXI зуунд хамгийн магадлалтай хэрэгжих үзэл баримтлалын нэг гарцаагүй мөн. Энэ бол хүн төрөлхтөний байгал, нийгмийн шалгарлаар урт удаан хугацаанд уламжлал болон тогтсон хаашаа ч зайлж хагацахын аргагүй өнгөрсөн, өдгөө, ирээдүйн хувь тавилан мөн. Өрнө, Дорнын соёлын нэгдлийг холбох үндсэн гол хэсэг нь гарцаагүй манай хоёр хөрш улс Орос, Хятад юм. Тэгэхээр хүн төрөлхтөний хөгжил дэвшилд эргэлт гаргах энэхүү стратегийн хамтрагчдын эгнээд Монгол ч бас оролцох нь гарцаагүй ээ.

Си Зиньпин төрийн тэргүүн болоод “эдийн засгийн туйл - Торгоны зам” болон “XXI зууны далайн торгоны зам” нэртэй хэтийн төлөвийг зарласан ба эдгээр стратегийн эхний бүлэгт Евразийн бүс нутаг бүхэлдээ харагдах юм. Си Зиньпин, В.Путин нар Монголд 2014 онд

20. Путин В.В: Новый интеграционный проект для Евразии-будущее, которое рождается сегодня... oko-planet.su/first/83475-.

хоорондоо долоо хоногийн зайтай айлчилсан ба айлчиллаар хийгдсэн хамтын ажиллагааны гэрээ хэлцэл энэ бүхэн зүгээр л нэг тохиолдлын зүйл ч бас биш ээ. Монгол Улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн санаачилсан Хятад, Орос, Монгол улсын төрийн тэргүүнүүдийн уулзалт²¹, болон “Талын зам” эдийн засгийн гарц зэрэг нь олон улсын хэмжээний хамтын ажиллагааны хэтийн төлөвийн хэрэгжилтийг нээж өгсөн, Евразийн хэтийн төлөвд оруулж байгаа хувь нэмэр, ирээдүйн хамгийн хүчтэй олон улсын нэгдлийн нэг болох найдварыг баталж байгаа улс төрийн үйл ажиллагаа юм.

Евразийн эх газрын Европын хэсэгт хандсан Оросын улс төрийн бодлогын нэг чухал акц²² бол Турк улсд 2015 оноос 6%- ийн хямд байгалийн хий нийлүүлж “хийн өмнөд шугам”- аа Туркээр дамжуулан татахаар тохиролцсон явдал юм. Үүнийг эдийн засаг, хамтын ажиллагааны “зөөлөн хүч”-ний хандлага биш гэх хүн гарахгүй нь ойлгомжтой. Дээр өгүүлсэн бүхэн Евразийн улс орнуудаас улс төрийн гадаад бодлогодоо “зөөлөн хүч”- ний аргыг олон улсын хүрээнд өргөн хүрээтэй хэрэглэж эхлээд байгаагийн үр дүн юм.

Өөрийнхөө байр сууринаас хэн ч ямар ч тодорхойлолт, мэдэгдэл хийсэн “зөөлөн хүч” нь хүч хэрэглэхгүй байх хандлага, ийм хандлагын хариуд хүчирхийллийг үүсгэж хэн ч турхирахгүй нь ойлгомжтой төдийгүй хүчиндэх боломж гарахгүй байх нь өөрөө сөрөг үр дагаварыг өдөөхгүйгээр уул / “зөөлөн хүч”-д / хандлагад “аяаараа л уусан” нэгэн цул болж орно гэсэн үг. Үүнийг өнгөцөөр харсанд Ж.Найг яг таг дагаагүй нийтлэг хандлага яриад байгаа мэт санагдавч угтаа Ж.Найгын хөндөж тавьсан “зөөлөн хүч”- ний онолыг хүмүүний дотоод сэтгэлийн орон зайн өргөн хүрээнд авч үзвэл энэ нь зөвхөн олон улсын бодлого, гадаад харилцаанд хэрэглэх төдийхнөөр хязгаарлагдахгүй цаашдаа сайтар гүнзгийрүүлэн судлахаас нийгмийн амьдрал хөгжил, дэвшилийг бүхэлд нь ерөнхийлөн хамарсан бүрэн цогц онол болохыг нь батлаад байх шиг ээ! Энэхүү цогц онолын суурь хэдий чинээ зөв тавигдана үр дүн нь нийгмийн аль ч хэсэгт гарцаагүй эерэгээр нөлөөлөх талаар

21. В.Путин, Си Зиньпин, Ц.Элбэгдорж нарын уулзалт:http://www.inet.mn/?left=yes&vdate=&vfile=5&v-l=archive&vmet_id=69374&vmet_main=9191&vofile=&vpage=&vt

22. "Южный поток" закрыт, но РФ активизирует сотрудничество по газу с...prime.ru/INDUSTRY/20141201/.

“Зөөлөн хүч”

дорнын мэргэд уйгагүй явуулсан эмперик судалгаагаараа аль эрт бүр 25 зууны тэртээ нотолсон байдаг. Харин бид судлаач Найгын дэвшүүлэн тавьсны ачаар дөнгөж саяхнаас л олон улсын харилцааны хүрээнд шинжлэх ухааны түвшинд хэлэлцэх болсныг зарим улс орны төр засгаас анхаарч улс хоорондын харилцаанд авч хэргэлэн хязгаардмал зааг хүрээнд “мунгинацгааж” байгаа нь харамсал дагуулах зүйл мөн.

Оросын стратег судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан судлаач В.Крягин²³: “зөөлөн хүч”- ний технологи “хүйтэн дайны” үед Баруунд хэрэглэгдэж байсан, харамсалтай нь тухайн үедээ “зөөлөн хүч” нь ЗСБНХУ-ыг хагалан бутаргах аюулд хүргэсэн сэтгэл зүйн мэдээлэлээр нөлөөлөх арга төдийгүй ард түмний ухамсарт хүрч нөлөөлдөг аюулыг араасаа дагуулсан, чиглэсэн объектоо сайн дураараа субъектдээ захирагдахаас өөр аргагүй болтол нь нөлөөлөх хэрэгсэл гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолтын ард мөн л миний дээр өгүүлсэн хүмүүний дотоод сэтгэлийн хувьсал, өөрчлөлт нуугдан буйг та бүхэн анзаарсан буйзаа

Бүх нийтийг хамарсан мэдээллийн технологи хүнийг ганцаардмал байдалд хүргэж зөвхөн нийгмийн шугам болох Facebook, Twitter–ээр л харьцдаг болгосон сүүлийн 10 жилд энэхүү мэдээллийн шугаман технологээр дамжин бүхий л төрлийн мэдээллийн “дайн”, “завхрал”, “мунхруулал” явагдаж улс хоорондын харилцааг ч хүчтэй өөрчилж чадахаар нөлөөллийн үйл ажиллагаа хамгийн өргөн хүрээнд цацагдаж энэ нь ард түмэн, улс орон, бүс нутаг цаашлаад дэлхийн өнцөг булан бүрт хүрч хүчтэй нөлөө үзүүлж байгаа энэ хэрэгсэл бол өнөө л бидний яриад байгаа “зөөлөн хүч”- ний арга, технологи бас гарцаагүй мөн.

ДҮГНЭЛТ

Аливаа улсын гадаад бодлогод “Зөөлөн хүч”, “ухаалаг хүч”, “хатуу хүч” –ний бодлого байдаг гэдгийг юуны түрүүнд америк эрдэмтэд олж тогтоосон байна. Тэдний бодлоор “ухаалаг хүч” гэдэг нь цэрэг, эдийн засаг, дипломатын боломжийн бүхий л аргаар нөгөө улсад байр суурь, нэр нөлөөгөө өргөжүүлэхийг хэлнэ. “Хатуу хүч” –ний бодлого гэдэг нь цэргийн хүчээр бүх асуудлыг шийдвэрлэхийг хэлнэ. Харин “зөөлөн хүч” гэдэг нь цэрэг зэвсэгийн бус аргаар тавьсан зорилгодоо хүрэхийг

23. Карякин.ВВ. <http://www.riss.ru/jomsocial/profile/594-karyakin-vladimir-vasilevich>

хэлнэ. Энэ утгаараа “зөөлөн хүч”-ний бодлогыг хүчирхэг гүрнүүд өөр өөрсдийн шугамаар, өөр өөрсдийн арга тактикаар хэрэгжүүлэхийг эрмэлзэцгээж байна. Тухайлбал, өнөөгийн Хятадын удирдлагаас гадаад орнуудад “Күнзийн хүрээлэн” гэх Хятадыг сурталчилахад чиглэсэн байгууллагыг олноор байгуулж, хятад хэл, соёл, урлаг, утга зохиолыг өргөнөөр сурталчилж байгаа нь өнөөх “зөөлөн хүч” –ний бодлогын тодорхой жишээ мөн. Үүний нэгэн адил Герман улс Конрад Аденауэрын сан, Фридрих Эбертийн сан зэргээр дамжуулан герман хэл, соёл зан заншилыг сурталчилж байгаа нь мөн л дээрхтэй агаар нэгэн зүйл ээ. Гэсэн хэдий ч “зөөлөн хүч”-ний бодлогоор ихээхэн амжилт олж байгаа улс бол яах аргагүй АНУ мөн. АНУ-ын Холливудын кинонууд, Силикон Валлейн технологийн амжилт, англи хэл зэрэг нь дэлхийн хөгжил дэвшлийн үлгэр жишээ болж, нэн ялангуяа залуучуудын зүгээс үлгэр дууриал авахыг эрмэлзэцгээх болсон гэдэг утгаараа мөнөөх “зөөлөн хүч” –ийг амьдралд хэрэгжүүлж буй бодитой жишээ юм. Гадаад бодлогын салбарт аваад үзвэл өнөөгийн Украины эргэн тойронд болж буй үйл явдал АНУ-ын зүгээс Украины талаар явуулсан “ зөөлөн хүч” –ний бодлогын тодорхой жишээ мөн. Оросууд Украинд болж буй үйл явдалтай холбогдуулан америкчуудыг буруутгаж байгаа нь үнэний хувьтай юм. АНУ өөрийн хүчирхэг санхүү, эдийн засгийн хөшүүргийг ашиглан, Украины үндсэрхэг үзэлтнүүдийг Оросын эсрэг турхирч, Украиныг Оросын санаачилсан Евразийн Эдийн засгийн хамтын нийгэмлэгээс салгаж, Европын Холбоонд, цаашлаад НАТО-д элсүүлэх зорилтоо “зөөлөн хүч”-ний бодлогоор халхавч хийсэн “зохион байгуулалттай зэвсэг²⁴” хэрэглэн арга буюу өөрийгөө дагахаас өөр аргагүйд хүргэн тулган хүлээлгэх замаар зорилтоо хангаж байна. Зөөлөн хүчний бодлого хүчний байгууллагуудаар дамжин хэрэгжээд ирэхээрээ учир утгаа алддагийг дээр өгүүлсэн жишээнээс харж болохоор байна.

Нэгтгээд дүгнэвэл, “зөөлөн хүч” -ний бодлого гэдэг нь улс төр, санхүү-эдийн засгийн хувьд хүчирхэг гүрнүүд өөрийн улс төрийн зорилгодоо хүрэх үүднээс, гадаад улсуудад өөрийн нөлөө, хүч чадлаа бэхжүүлэх хэрэгсэл мөн.

24. Овчинский В. С., доктор юридических наук, Сундиев И. Ю., доктор философских наук “Организационное оружие”: Функциональный генезис и система технологий XXI века trueinform.ru/modules.php?file.